



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/561

Мандалговь

Агуулахын байршил тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Говь-Угтаал сумын нутагт орших "Хан Хас Трейд" ХХК-ний 4386А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг хавсралтаар тогтоосугай.

Хоёр. Тэсрэх материалын агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд хуулийн хугацаанд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж)-т үүрэг болгосугай.

Гурав. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг мэдээллийн нэгдсэн санд хуулийн хугацаанд бүртгүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48801071

Аймгийн Засаг даргын 2018 оны 12
дугаар сарын 14-ны өдрийн 1564
дугаар захирамжийн хавсралт



ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХЫН БАЙНГЫН БАЙРШЛЫН СОЛБИЛЦОЛ

Цэгийн дугаар	X	Y
1.	45° 48' 27.6"	107° 35' 22.9"
2.	45° 48' 24.4"	107° 35' 23.0"
3.	45° 48' 24.5"	107° 35' 26.7"
4.	45° 48' 27.6"	107° 35' 26.5"